

# ИХЭР МӨРӨН АУДИТ ХХК



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Арбулаг сумын ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2023/128/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)

Мөрөн сум 2023 он

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,  
тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар

Утас: 88883317 Цахим хаяг: [erdenebaatara@audit.gov.mn](mailto:erdenebaatara@audit.gov.mn)

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр

Утас: 99089114 Цахим хаяг: [tegshdelgerb@audit.gov.mn](mailto:tegshdelgerb@audit.gov.mn)

Аудитор: С.Гансүх

Утас: 95908400 Цахим хаяг: [gansukh.s@audit.gov.mn](mailto:gansukh.s@audit.gov.mn)

Ихэрмөрөн-Аудит ХХК-ийн захирал Б.Мядагмаа

Утас: 99389208 Цахим хаяг: [b\\_myadagmaaa@yahoo.com](mailto:b_myadagmaaa@yahoo.com)

Аудитор Б.Нэргүй

Утас: 99010744 Цахим хаяг: [nerguib82@gmail.com](mailto:nerguib82@gmail.com)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БШУС	Боловсрол, шинжлэх ухааны сайд
БСШУС	Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд
БШУГ	Боловсрол, шинжлэх ухааны газар
УИХ	Улсын их хурал
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал



## ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,  
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120  
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

2023.02.24 № 01/129  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

АРБУЛАГ СУМЫН ЕРӨНХИЙ  
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ  
Л.ДАВААДОРЖ ТАНАА

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Арбулаг сумын ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Арбулаг сумын ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан "Хувьсах зардлын дундаж нормативаар төсөв хуваарилах, санхүүжүүлэх журам"-ын 8.7 дахь заалтад төсвийн жилийн эцэст зарцуулагдаагүй үлдсэн мөнгөн хөрөнгийг улсын төсөвт татан төвлөрүүлэлгүйгээр дараагийн төсвийн жилд шилжүүлэн зарцуулахаар заасантай холбоотой мөнгөн хөрөнгө данс 2,264.6 мянган төгрөгийн үлдэгдэлтэй гарсан байна.

### Аудитын гол асуудал

Тайлант онд боловсролын байгууллагыг үйл ажиллагааны үр дүн, чанар, гүйцэтгэл, сургалтын хөтөлбөрийн бодит өртөгт суурилсан хувьсах зардлаар санхүүжүүлэх, суралцагчийн сурлагын чанарыг хараат бусаар үнэлэх, багшийн ажлын үр дүнг суралцагчийн сурлагын чанартай уялдуулж үнэлэх, үр дүн бүтээмжид суурилсан цалин хөлсний бодлого хэрэгжүүлэхэд чиглэсэн холбогдох эрх зүйн актуудыг шинэчлэн баталж, мөрдүүлсэн байна.

### Бусад асуудлын хэсэг

Сургуулийн захирал Арбулаг сумын Засаг даргатай хийсэн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 5 зорилтын хүрээнд төлөвлөж 93.2 хувьтай дүгнэгдсэн байна.

### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



А. ЭРДЭНЭБААТАР

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>363,270,772.23</b>	<b>496,985,559.26</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b>0.00</b>	<b>2,264,560.51</b>
<b>31200</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	<b>0.00</b>	<b>2,264,560.51</b>
<b>31220</b>	<b>Гадаад валют</b>	<b>0.00</b>	<b>2,264,560.51</b>
31221	Төрийн сангийн харилцах	0.00	2,264,560.51
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>321,311.14</b>	<b>10,941,610.00</b>
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	321,311.14	2,774,310.00
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	0.00	512,300.00
<b>33500</b>	<b>Бусад авлага</b>	<b>0.00</b>	<b>7,655,000.00</b>
33510	Байгууллагаас авах авлага	0.00	7,655,000.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>362,949,461.09</b>	<b>483,779,388.75</b>
<b>35100</b>	<b>Түүхий эд материал</b>	<b>68,301,205.58</b>	<b>68,301,205.58</b>
35110	Тусгай зориулалттай материал	59,054,640.00	59,054,640.00
35130	Эм боох материал	9,246,565.58	9,246,565.58
<b>35400</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>294,648,255.51</b>	<b>415,478,183.17</b>
35410	Бичиг хэргийн материал	5,468,375.05	12,108,635.05
35420	Аж ахуйн материал	5,756,729.00	6,226,209.00
35440	Түлш, шатах тослох материал	51,460,497.52	71,480,438.02
35450	Барилгын засварын материал	32,460,597.00	86,377,725.21
35460	Хүнсний материал	30,680,419.87	67,652,295.82
35470	Бусад хангамжийн материал	168,821,637.07	171,632,880.07
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,073,260,889.40</b>	<b>1,096,013,242.65</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>1,073,260,889.40</b>	<b>1,096,013,242.65</b>
<b>39200</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>970,268,889.40</b>	<b>993,021,242.65</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	955,557,223.51	955,557,223.51
39202	Хуримтлагдсан элэгдэл	-138,030,361.12	-181,494,736.60
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	261,361,026.00	338,538,334.40
39206	Хуримтлагдсан элэгдэл	-187,766,758.52	-208,265,049.48
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	159,885,992.14	175,227,838.66
39208	Хуримтлагдсан элэгдэл	-101,666,704.59	-111,475,299.82
39217	Ном	20,928,471.98	24,932,931.98
<b>39300</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>102,992,000.00</b>	<b>102,992,000.00</b>
39301	Програм хангамж	737,000.00	737,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-737,000.00	-737,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	102,992,000.00	102,992,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>1,436,531,661.63</b>	<b>1,592,998,801.91</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>156,592.30</b>	<b>2,942,608.99</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>156,592.30</b>	<b>2,942,608.99</b>
<b>41300</b>	<b>Өглөг</b>	<b>156,592.30</b>	<b>2,942,608.99</b>
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	156,592.30	2,942,608.99
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>1,436,375,069.33</b>	<b>1,590,056,192.92</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>1,436,375,069.33</b>	<b>1,590,056,192.92</b>
51100	Засгийн газрын оруулсан капитал	1,093,415,107.57	0.00
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	1,093,415,107.57	0.00
51101	Өмч /төрийн/ /ТӨҮГ/	0.00	1,093,415,107.57
<b>51200</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>-262,031,445.20</b>	<b>-108,350,321.61</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	-306,752,745.16	-262,031,445.20
51220	Тайлант үеийн үр дүн	44,721,299.96	153,681,123.59
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	604,991,406.96	604,991,406.96
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>1,436,531,661.63</b>	<b>1,592,998,801.91</b>

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

**/төгрөгөөр/**

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,234,533,473.42</b>	<b>1,635,853,310.92</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>42,951,976.06</b>	<b>104,091,710.92</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>42,951,976.06</b>	<b>104,091,710.92</b>
<b>120004</b>	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>0.00</b>	<b>3,999,400.00</b>
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	1,560,400.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	2,439,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	39,129,563.86	49,866,614.92
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	3,822,412.20	50,225,696.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,191,581,497.36</b>	<b>1,531,761,600.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>1,112,126,400.00</b>	<b>1,372,586,200.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	0.00	1,372,586,200.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,112,126,400.00	0.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>4,945,297.36</b>	<b>0.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,945,297.36	0.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>74,509,800.00</b>	<b>159,175,400.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	74,509,800.00	159,175,400.00
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,169,887,963.99</b>	<b>1,488,631,354.08</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,169,887,963.99</b>	<b>1,488,631,354.08</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,142,538,167.57</b>	<b>1,422,730,787.96</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>840,288,200.00</b>	<b>1,055,768,660.71</b>
210101	Үндсэн цалин	553,741,026.25	768,746,213.87
210102	Нэмэгдэл	223,491,828.12	203,549,690.31
210104	Урамшуулал	63,055,345.63	83,472,756.53
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>113,117,488.86</b>	<b>131,600,111.36</b>
210201	Тэтгэврийн даатгал	79,506,088.85	89,651,115.52
210202	Тэтгэмжийн даатгал	8,402,800.01	10,509,288.71
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,722,300.00	8,394,070.96
210204	Ажилгүйдлийн даатгал	1,680,500.00	2,095,057.87
210205	Эрүүл мэндийн даатгал	16,805,800.00	20,950,578.30
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>37,022,457.30</b>	<b>44,545,382.80</b>
210301	Гэрэл, цахилгаан	10,104,717.30	14,360,323.30
210302	Түлш, халаалт	26,317,740.00	29,980,059.50
210303	Цэвэр, бохир ус	600,000.00	205,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>36,679,368.74</b>	<b>19,814,160.00</b>
210401	Бичиг хэрэг	4,525,600.00	6,745,240.00
210402	Тээвэр, шатахуун	5,500,000.00	8,099,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	86,900.00	0.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	651,061.00	0.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,666,550.00	4,969,320.00
210408	Бараа материал акталсны зардал	20,249,257.74	0.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>41,917,622.96</b>	<b>59,933,319.88</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,289,138.42	0.00
210502	Хоол, хүнс	39,628,484.54	59,933,319.88
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>1,061,100.00</b>	<b>3,282,300.00</b>
210604	Урсгал засвар	1,061,100.00	3,282,300.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>670,200.00</b>	<b>0.00</b>
210702	Дотоод албан томилолт	670,200.00	0.00

<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>4,053,900.00</b>	<b>9,529,500.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,333,900.00	1,048,100.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	720,000.00	0.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	0.00	8,481,400.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>67,727,829.71</b>	<b>98,257,353.21</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	23,631,924.79
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	480,000.00	0.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	67,247,829.71	74,625,428.42
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>27,349,796.42</b>	<b>65,900,566.12</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>27,319,796.42</b>	<b>64,443,204.17</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	24,169,796.42	42,391,504.17
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,150,000.00	22,051,700.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>0.00</b>	<b>1,457,361.95</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	1,457,361.95
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>30,000.00</b>	<b>0.00</b>
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	30,000.00	0.00
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>64,645,509.43</b>	<b>147,221,956.84</b>
<b>IV</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН</b>	<b>0.00</b>	<b>6,459,166.75</b>
145002	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз	0.00	6,459,166.75
<b>V</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>19,924,209.47</b>	<b>0.00</b>
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худ-саны гарз	19,924,209.47	0.00
<b>VI</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>	<b>44,721,299.96</b>	<b>153,681,123.59</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН</b>	<b>1,191,581,497.36</b>	<b>1,535,248,700.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>0.00</b>	<b>3,487,100.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>0.00</b>	<b>3,487,100.00</b>
<b>120004</b>	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>0.00</b>	<b>3,487,100.00</b>
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	1,048,100.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	2,439,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,191,581,497.36</b>	<b>1,531,761,600.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>1,112,126,400.00</b>	<b>1,372,586,200.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	0.00	1,372,586,200.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,112,126,400.00	0.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>4,945,297.36</b>	<b>0.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,945,297.36	0.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>74,509,800.00</b>	<b>159,175,400.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	74,509,800.00	159,175,400.00
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>1,154,194,561.00</b>	<b>1,484,411,339.49</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,154,194,561.00</b>	<b>1,484,411,339.49</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,121,014,561.00</b>	<b>1,400,175,377.54</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>840,288,200.00</b>	<b>1,058,542,970.71</b>
210101	Үндсэн цалин	553,741,026.25	771,520,523.87
210102	Нэмэгдэл	223,491,828.12	203,549,690.31
210104	Урамшуулал	63,055,345.63	83,472,756.53
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>113,438,800.00</b>	<b>131,278,800.22</b>

210201	Тэтгэврийн даатгал	79,827,400.00	89,329,804.38
210202	Тэтгэмжийн даатгал	8,402,800.00	10,509,288.71
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,722,300.00	8,394,070.96
210204	Ажилгүйдлийн даатгал	1,680,500.00	2,095,057.87
210205	Эрүүл мэндийн даатгал	16,805,800.00	20,950,578.30
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>49,500,000.00</b>	<b>62,893,606.61</b>
210301	Гэрэл, цахилгаан	9,948,125.00	12,688,606.61
210302	Түлш, халаалт	38,951,875.00	50,000,000.00
210303	Цэвэр, бохир ус	600,000.00	205,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>30,942,861.00</b>	<b>0.00</b>
210401	Бичиг хэрэг	1,729,800.00	0.00
210402	Тээвэр, шатахуун	5,500,000.00	0.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	86,900.00	0.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	934,761.00	0.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	22,691,400.00	0.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>45,658,200.00</b>	<b>78,569,800.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	842,000.00	0.00
210502	Хоол, хүнс	41,000,000.00	78,569,800.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,816,200.00	0.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>26,809,800.00</b>	<b>13,000,000.00</b>
210602	Тавилга	1,800,000.00	0.00
210604	Урсгал засвар	25,009,800.00	13,000,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>670,200.00</b>	<b>0.00</b>
210702	Дотоод албан томилолт	670,200.00	0.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>5,478,000.00</b>	<b>9,529,500.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,758,000.00	1,048,100.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	720,000.00	0.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	0.00	8,481,400.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>8,228,500.00</b>	<b>46,360,700.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	33,638,500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,228,500.00	12,722,200.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>33,180,000.00</b>	<b>84,235,961.95</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>33,150,000.00</b>	<b>82,778,600.00</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	30,000,000.00	60,726,900.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,150,000.00	22,051,700.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>0.00</b>	<b>1,457,361.95</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	1,457,361.95
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>30,000.00</b>	<b>0.00</b>
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	30,000.00	0.00
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>37,386,936.36</b>	<b>50,837,360.51</b>
<b>V</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	<b>37,386,936.36</b>	<b>48,572,800.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>37,386,936.36</b>	<b>48,572,800.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>37,386,936.36</b>	<b>48,572,800.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	37,386,936.36	48,572,800.00
<b>VI</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>	<b>-37,386,936.36</b>	<b>-48,572,800.00</b>
<b>VIII</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)</b>	<b>0.00</b>	<b>2,264,560.51</b>
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	2,264,560.51

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

**/Төгрөгөөр/**

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны НИЙТ дүн
<b>1</b>	<b>2020 оны 12-р сарын 31-х үлдэгдэл</b>	<b>1,093,415,107.57</b>	<b>606,808,106.96</b>	<b>-308,569,445.16</b>	<b>1,391,653,769.37</b>
2	Нягтлан бодох бүртгэлийн өөрчлөлт	0.00	0.00	1,816,700.00	1,816,700.00
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,093,415,107.57	606,808,106.96	-306,752,745.16	1,393,470,469.37
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.00	-1,816,700.00	0.00	-1,816,700.00
9	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	44,721,299.96	44,721,299.96
<b>10</b>	<b>2021 оны 12-р сарын 31-х үлдэгдэл</b>	<b>1,093,415,107.57</b>	<b>604,991,406.96</b>	<b>-262,031,445.20</b>	<b>1,436,375,069.33</b>
12	Нягтлан бодох бүртгэлийн өөрчлөлт	1,093,415,107.57	604,991,406.96	-262,031,445.20	1,436,375,069.33
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,093,415,107.57	604,991,406.96	-262,031,445.20	1,436,375,069.33
19	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	153,681,123.59	153,681,123.59
<b>20</b>	<b>2022 оны 12-р сарын 31-х үлдэгдэл</b>	<b>1,093,415,107.57</b>	<b>604,991,406.96</b>	<b>-108,350,321.61</b>	<b>1,590,056,192.92</b>

**2.5.1 Аудит хийсэн улсын төсвийн гүйцэтгэлийн тайлан**

**/Төгрөгөөр/**

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>1,376,073,300.00</b>	<b>1,373,808,739.49</b>	<b>2,264,560.51</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,376,073,300.00</b>	<b>1,373,808,739.49</b>	<b>2,264,560.51</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,293,294,700.00</b>	<b>1,291,030,139.49</b>	<b>2,264,560.51</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>986,899,500.00</b>	<b>984,634,939.49</b>	<b>2,264,560.51</b>
210101	Үндсэн цалин	736,354,400.00	707,585,213.24	<b>28,769,186.76</b>
210102	Нэмэгдэл	194,558,100.00	197,358,846.28	<b>-2,800,746.28</b>
210104	Урамшуулал	55,987,000.00	79,690,879.97	<b>23,703,879.97</b>
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>123,362,400.00</b>	<b>123,362,400.00</b>	<b>0.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	83,886,500.00	83,886,500.00	<b>0.00</b>
210202	Тэтгэмжийн даатгал	9,868,900.00	9,868,900.00	<b>0.00</b>
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,899,200.00	7,895,200.00	<b>4,000.00</b>
210204	Ажилгүйдлийн даатгал	1,973,800.00	1,973,800.00	<b>0.00</b>
210205	Эрүүл мэндийн даатгал	19,738,000.00	19,738,000.00	<b>0.00</b>
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>78,569,800.00</b>	<b>78,569,800.00</b>	<b>0.00</b>

Арбулаг сумын ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210502	Хоол, хүнс	78,569,800.00	78,569,800.00	0.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>9,529,500.00</b>	<b>9,529,500.00</b>	<b>0.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,048,100.00	1,048,100.00	0.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	8,481,400.00	8,481,400.00	0.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>94,933,500.00</b>	<b>94,933,500.00</b>	<b>0.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	82,211,300.00	82,211,300.00	0.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	12,722,200.00	12,722,200.00	0.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>82,778,600.00</b>	<b>82,778,600.00</b>	<b>0.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>82,778,600.00</b>	<b>82,778,600.00</b>	<b>0.00</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	60,726,900.00	60,726,900.00	0.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	22,051,700.00	22,051,700.00	0.00
<b>III</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>1,376,073,300.00</b>	<b>1,376,073,300.00</b>	<b>0.00</b>
<b>31</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>1,372,586,200.00</b>	<b>1,372,586,200.00</b>	<b>0.00</b>
310001	Улсын төсвөөс санхүүжих	1,372,586,200.00	1,372,586,200.00	0.00
<b>35</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>3,487,100.00</b>	<b>3,487,100.00</b>	<b>0.00</b>
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,048,100.00	1,048,100.00	0.00
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,439,000.00	2,439,000.00	0.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	2,264,560.51	-2,264,560.51
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>79.00</b>	<b>79.00</b>	<b>0.00</b>
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	0.00
620002	Гүйцэтгэх ажилтан	46.00	46.00	0.00
620003	Үйлчлэх ажилтан	32.00	32.00	0.00

2.5.2 Аудит хийсэн Орон нутгийн төсвийн гүйцэтгэлийн тайлан /төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>159,324,200.00</b>	157,866,838.05	1,457,361.95
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>159,324,200.00</b>	157,866,838.05	1,457,361.95
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>159,324,200.00</b>	157,866,838.05	1,457,361.95
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>75,307,600.00</b>	<b>74,056,831.22</b>	1,250,768.78
210101	Үндсэн цалин	75,307,600.00	75,101,006.83	206,593.17
210102	Нэмэгдэл	0	6,190,844.03	-6,190,844.03
210104	Урамшуулал	0	3,781,876.56	-3,781,876.56
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>8,091,200.00</b>	<b>7,916,400.22</b>	174,799.78
210201	Тэтгэврийн даатгал	5,562,100.00	5,443,304.38	118,795.62
210202	Тэтгэмжийн даатгал	654,400.00	640,388.71	14,011.29
210203	ҮОМШӨ-ний даатгал	510,000.00	498,870.96	11,129.04
210204	Ажилгүйдлийн даатгал	124,100.00	121,257.87	2,842.13
210205	Эрүүл мэндийн даатгал	1,240,600.00	1,212,578.30	28,021.70

<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>62,925,400.00</b>	<b>62,893,606.61</b>	31,793.39
210301	Гэрэл, цахилгаан	11,425,400.00	12,688,606.61	-1,263,206.61
210302	Түлш, халаалт	50,000,000.00	50,000,000.00	0.00
210303	Цэвэр, бохир ус	1,500,000.00	205,000.00	1,295,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>13,000,000.00</b>	<b>13,000,000.00</b>	0.00
210604	Урсгал засвар	13,000,000.00	13,000,000.00	0.00
<b>III</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>159,324,200.00</b>	157,866,838.05	1,457,361.95
<b>32</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>159,324,200.00</b>	157,866,838.05	1,457,361.95
320001	Орон нутгийн төсвөөс	159,324,200.00	157,866,838.05	1,457,361.95
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		0	0.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		0	0.00

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

**1.6.1 Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар:** Арбулаг сумын ерөнхий боловсролын сургууль нь бага болон суурь, дунд боловсрол олгох сургалтын үйл ажиллагаа явуулдаг, Боловсрол Шинжлэх Ухааны Яамны харьяа байгууллага юм.

Сургуулийн үйл ажиллагааны үндсэн зорилт нь суралцагчдад боловсролын стандартаар тогтоосон бага, суурь, бүрэн дунд боловсрол эзэмшүүлэх, тэдний хөгжих, төлөвших үйл явцыг шинжлэх ухааны үндэстэй удирдах, зохион байгуулах, эцэг, эх, асран хамгаалагчтай хамтран ажиллах, тэдэнд мэргэжлийн зөвлөгөө, туслалцаа дэмжлэг үзүүлэхэд оршино.

Тус байгууллага нь 2022 онд “Сурагчдын ялгаатай байдлыг хүндэтгэж, сурлагын хоцрогдлыг нөхөх, арилгах үйл ажиллагааг чанартай зохион байгуулах” гэсэн зорилго тавьж ажилласан ба энэхүү зорилгын хүрээнд багш, сургууль, суралцагч, эцэг эхийн хөгжилд чиглэсэн зорилтуудыг дэвшүүлэн ажилласан байна.

Сургуулийн захирал Арбулаг сумын засаг даргатай хийсэн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 5 зорилт төлөвлөж, 93.9 хувьтай дүгнэгдсэн байна.

#### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

**Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар:** 2022 онд боловсролын салбарт шинэчлэл хийж, түүнийг дэмжсэн төсвийг батлан хэрэгжүүлэхийг зорьсон байна. Боловсролын тухай хууль, Сургуулийн өмнөх боловсролын тухай хуулийг 2021 онд өөрчлөн найруулснаар гүйцэтгэл, үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоог бий болгож, “хувьсах зардал”-ыг улсын төсвөөс санхүүжүүлэх болсон байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

1. Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулга 2022 оны 1 дүгээр сарын 1-ээс хэрэгжиж эхэлсэн.
2. Төрийн бүх шатны байгууллага, нийтийн алба, тэдгээрийн үйл ажиллагаанд санхүүгийн сахилга бат мөрдүүлж, ил тод байдлыг хангах, үр ашгийг нэмэгдүүлэх, үрэлгэн байдлыг хязгаарлах хяналт тавихад чиглэсэн “Төрийн хэмнэлтийн тухай” хууль хэрэгжиж эхэлсэн.

- 3. Төрийн үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг Засгийн газрын 2022 оны 107 дугаар тогтоолоор тогтоосон ба 2022 оны 192 дугаар тогтоолоор эрүүл мэндийн салбараас бусад төрийн үйлчилгээний байгууллага болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах албан тушаалын цалингийн доод хэмжээг өөрчлөн тогтоосон байна.
- 4. Боловсролын салбарт хийж байгаа шинэчлэл, үйл ажиллагаа, төсөв санхүүг дэмжсэн шийдвэрийг Засгийн газар, салбарын яамнаас гаргаж мөрдүүлсэн байна. Тухайлбал:
  - Засгийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 403 дугаар тогтоолоор Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Боловсролын ерөнхий газрыг байгуулсан ба 2022 оны 131 дүгээр тогтоолоор Боловсролын ерөнхий газрын даргыг Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын, мэргэжлийн боловсролын, техникийн боловсролын сургалтын байгууллагын төсвийн төвлөрүүлэн захирагчаар баталсан байна.
  - Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолоор “Сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэхэд нэг суралцагчдад хувьсах зардлын дундаж норматив, түүний бүрэлдэхүүн”, “Төрийн болон орон нутгийн өмчит цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн нэг суралцагчид ногдох хувьсах зардлын байршил, хэв шинж, хүүхдийн тооноос хамаарсан өсөн нэмэгдэх итгэлцүүр”, “Хувьсах зардлын дундаж нормативаар төсөв хуваарилах, санхүүжүүлэх аргачлал” баталсан байна.
  - БШУС-ын 2022 оны А/122 дугаар тушаалаар Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолыг үндэслэн төрийн болон орон нутгийн өмчит сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургуулийн үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн зарим албан хаагчийн цалингийн хэмжээг тогтоосон.
  - БШУС-ын 2022 оны А/170 дүгээр тушаалаар “төрийн болон орон нутгийн өмчийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн хичээл сургалтын үйл ажиллагааны зардлыг төлөвлөх хуваарилах заавар”-ыг 1 дүгээр, “багшийн тасралтгүй хөгжлийг дэмжих, үйл ажиллагааны санхүүжилт, түүнийг зарцуулах заавар”-ыг 2 дугаар, “цахим хэрэглээний зардлыг төлөвлөх, хуваарилах заавар”-ыг 3 дугаар, “тоног төхөөрөмжийн нөхөн хангалтын зардлыг төлөвлөх хуваарилах, санхүүжүүлэх зааврыг 4 дүгээр хавсралтаар тус тус баталсан байна.
  - БШУС-ын 2022 оны А/259 дүгээр тушаалаар “Цэцэрлэг, ерөнхий боловсролын багшийг эрүүл мэндийн нэмэлт үзлэг, оношилгоонд хамруулах заавар”-ыг баталсан байна.
  - БШУС-ын 2022 оны А/430 дугаар тушаалаар багшийн ажлыг үнэлэх журмыг шинэчлэн баталсан.
  - БШУС-ын 2022 оны А/452 дугаар тушаал “Хувьсах зардлын тоног төхөөрөмжийн нөхөн хангалтын тухай”
  - БШУС-ын 2022 оны А/465 дугаар тушаал “ Ерөнхий боловсролын сургуульд кабинет, лаборатори, цахим сургалтын танхим байгуулах, ашиглах нийтлэг журам”
  - БШУС-ын 2022 оны А/500 дугаар тушаалаар төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагааны гүйцэтгэлийн чанар, үр дүнг үнэлж, үр дүнгийн нэмэлт урамшууллын зардлыг санхүүжүүлэхэд баримтлах чиглэлийг баталсан.

**Байгууллагын дотоод хяналтын талаар:** Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”-ийн дагуу сургуулийн захирлын 2021 оны А/42

тоот тушаалаар дотоод хяналт хэрэгжүүлэх ажлын хэсгийг 5 хүний бүрэлдэхүүнтэй баталсан байна.

Дотоод хяналтын ажлын хэсэг нь 2022 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө батлуулан, тухайн онд нийт 5 удаа дотоод хяналтыг хэрэгжүүлсэн байна. Дотоод хяналтаар 3 зөрчлийг илрүүлж, 1 зөвлөмжийг удирдлагад хүргүүлж ажилласан боловч дотоод хяналтын үр нөлөөг дээшлүүлэх, хяналтаар илрүүлсэн зөрчил, дутагдлыг арилгахад чиглэсэн үйл ажиллагааг сайжруулан ажилласан байна.

Түүнчлэн 2022 онд сургуулийн захирлын тушаалаар шинээр гарсан дүрэм, журмуудын хэрэгжилтийг хангах, байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, төсөв санхүүг зарцуулах, түүнд хяналт тавих, худалдан авах ажиллагааг зохион байгуулах, шинээр гарсан дүрэм, журмын хэрэгжилтийг хангах чиг үүрэг бүхий зөвлөл, ажлын хэсэг, багуудыг томилж ажиллуулсан байна.

Тус сургууль нь 2022 онд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны 64 дүгээр тогтоолоор төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг тооллогыг зохион байгуулсан байна.

Эдгээр зохион байгуулалтын арга хэмжээний хүрээнд байгууллагын санхүүгийн үйл ажиллагааны дотоод хяналтын 1 ба 2 дугаар үе шатны тогтолцоо бий болсон байна гэж үзлээ.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ.

Тайлант онд Хөвсгөл аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба болон татвар, нийгмийн даатгалын байгууллагуудаас хяналт шалгалт хийгээгүй байна.

**3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Арбулаг сумын ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан иж бүрдийн дагуу бэлтгэж толилуулсан байна гэж үзлээ.

Харин төсвийн гүйцэтгэлийн тайланг мөнгөн сууриар бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5 дахь заалтад заасан заалтын дагуу иж бүрэн ирүүлсэн.

**Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар:** Санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа БСШУС-ын 2017 оны А/40 дүгээр тушаалаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг үйл ажиллагаандаа ашиглаж, санхүү, төсөв нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа УСНББОУС, Засгийн газар, Сангийн яамнаас гаргасан журам, зааврыг мөрдөж ажилласан байна.Тус Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт тусгагдсан зарим журам заавар шинэчлэгдсэнтэй холбоотойгоор нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг өөрийн байгууллагын үйл ажиллагаандаа тохируулан боловсруулах шаардлага тулгарч байна.

**3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд**

Арбулаг сумын ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад

мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 2,264.6 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Мөнгөн хөрөнгө	00.0	2,264.6	2,264.6
Авлага	321.3	10,941.6	10,620.3
Бараа материал	362,949.5	483,779.4	120,829.9
Биет хөрөнгө	970,268.9	993,021.2	22,752.4
Биет бус хөрөнгө	102,992.0	102,992.0	00.0
<b>Нийт хөрөнгө</b>	<b>1,436,531.7</b>	<b>1,592,998.8</b>	<b>156,467.1</b>
Дансны өглөг	156.6	2,942.6	2,786.0
Бусад урт хугацаат өглөг	00.0	00.0	00.0
Засгийн газрын хувь оролцоо	1,436,375.1	1,590,056.2	153,681.1
Хуримтлагдсан үр дүн	-262,031.4	-108,350.3	153,681.1
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>1,436,531.7</b>	<b>1,592,998.8</b>	<b>156,467.1</b>

Дээрх хүснэгтээс харахад мөнгөн хөрөнгө, бараа материал, засгийн газрын хувь оролцоо нэмэгдсэн, биет болон биет бус хөрөнгө буурсан, өглөг данс буурсан үзүүлэлттэй байна. Үүнд:

1. Тайлант онд мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 2,264.6 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь улсын төсвөөс хүлээн авсан санхүүжилтийн зарцуулагдаагүй үлдэгдлийг буцаан төвлөрүүлээгүй нь гол нөлөө үзүүлсэн байна.
2. Бараа материал данс өмнөх оноос 120,829.6 мянган төгрөгөөр нэмэгдэхэд хангамжийн материал 120,829.6 мянган төгрөгөөр өссөн нь нөлөөлсөн байна.
3. Авлага данс 10,620.3 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь ажиллагсадтай хийх тооцооны авлага 2,453.0 мянган төгрөг, төлбөртэй үйлчилгээний авлага 512.3 мянган төгрөгөөр, байгууллагаас авах авлага 7,655.0 мянган төгрөгөөр тус тус өссөн байна.
4. Биет хөрөнгө 22,752.4 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд 98,573.6 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдэж, 2,050.0 мянган төгрөгийн хөрөнгө хасагдсан, үндсэн хөрөнгийн элэгдэл 74,625.4 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь гол нөлөө үзүүлсэн байна.
5. Засгийн газрын хувь оролцоо өмнөх оноос 153,681.1 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант үеийн үр дүнгээр нэмэгдсэн байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

##### Улсын төсвөөс санхүүжих зардлын төлөвлөлт:

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,724,300.0 мянган төгрөгөөр төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн ба төсвийн төслийн саналаас 188,900.0 мянган төгрөгөөр өсгөж 1,535,400.0 мянган төгрөгөөр баталсан байна.

Энэ нь 2022 оны төсвийн төлөвлөлтийг зардлын эдийн засгийн ангиллаар төлөвлөснийг УИХ-аар үр дүн, гүйцэтгэлд суурилсан санхүүжилт олгохоор баталсантай холбоотой,

төсвийн жилийн дундуур төсвийн ерөнхийлөн захирагчийн шийдвэрээр удаа дараа нэмэгдүүлэн баталсан байна. Үүнд:

Байгууллагын 2022 оны төсвийн зарлагын сар, улирлын хуваарийг БШУС-ын 2022 оны 3 дугаар сарын 24-ны А/105 тоот тушаалаар баталж ирүүлсэн ба 2022 оны 10 дугаар сарын 7-ний өдрийн А/258 дугаар тушаал, 12 дугаар сарын 30-ны өдрийн А/392 тоот тушаалаар тус тус өөрчлөлт оруулж, анхны баталсан төсвийг 159,326.7 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэн байна.

Ингэснээр нийт төсвийн зарлага 1,376,073.3 мянган төгрөг болж, 1,372,586.2 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэх, 3,487.1 мянган төгрөгийг төсөвт байгууллагын өөрийн орлогоор санхүүжүүлэхээр баталжээ.

### Орон нутгийн төсвөөс санхүүжих зардлын төлөвлөлт:

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд орон нутгийн төсвөөс 253,968.9 мянган төгрөгийн зардлыг санхүүжүүлэхээр төлөвлөж, Арбулаг сумын ЗДТГ-т хүргүүлсэн байна.

Алаг-Эрдэнэ сумын ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн хуралдааны 02 тоот тогтоолоор төлөвлөсөн дүнг 253,968.9 мянган төгрөгөөр баталсан байна.

Энэ нь төсвийн төсөлд зөвхөн байр ашиглалтын тогтмол зардлаар тооцоолсныг байр ашиглалтын үйлчилгээний зардлыг нэмж баталсантай холбоотой.

Алаг-Эрдэнэ сумын ИТХ-ын 2022 оны 9 дугаар сарын 10-ны өдрийн хуралдааны 01 тоот тогтоолоор тус сургуулийн төсөвт тодотгол хийж, 159,070.2 мянган төгрөгөөр бууруулан, 159,324.2 мянган төгрөгөөр баталсан нь төрийн үйлчилгээний албан хаагчдын цалин, шимтгэлийн зардлыг улсын төсвөөс санхүүжүүлэх болсонтой холбоотой.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,372,586.2 мянган төгрөгийн санхүүжилт хүлээн авч, үйл ажиллагааны орлогоор 3,487.1 мянган төгрөг нийт 1,376,073.3 мянган төгрөгийн орлого бүрдүүлж 1,373,808.6 мянган төгрөгийг зарцуулж 2,264.5 мянган төгрөгийн үлдэгдэлтэй, орон нутгийн төсвөөс 157,866.8 мянган төгрөгийн санхүүжилтийг хүлээн авч зарцуулаагүй үлдэгдэл 1,457.4 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсөвт байгууллагын өөрийн орлого 3,487.1 мянган төгрөг төвлөрүүлэхээс 3,487.1 мянган төгрөгийг төвлөрүүлж 100.0 хувийн гүйцэтгэлтэй байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,531,675.4 мянган төгрөг буюу 99.7 хувь байгаа нь бараа үйлчилгээний зардлын төсвийг 3,722.1 мянган төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

<i>/мянган төгрөгөөр/</i>					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
<b>Улсын төсвөөс санхүүжих</b>					
1	80226- Байр ашиглалтын үйлчилгээ	3,392.60	3,392.60	0.00	100
2	80312-Сургалт семинар	1,696.30	1,696.30	0.00	100
3	81605-Эрүүл мэндийг дэмжих	3,901.50	3,901.50	0.00	100
4	81801-Үдийн цай хөтөлбөр	60,726.90	60,726.90	0.00	100
5	81816-Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	37,465.00	37,465.00	0.00	99.2
	81806-Дотуур байр	115,865.10	113,600.50	2,264.60	98.0
6	81823-Боловсролын байгууллагын багш, ажилчдын мэргэжил дээшлүүлэх	7,633.30	7,633.20	0.10	83.5
7	81834-Боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө хөтөлбөрийг хэрэгжүүлэх	903,304.20	903,304.20	0.00	98
8	81835-Сургалтын хэвийн үйл ажиллагаа	238,601.30	238,601.30	0.00	97.6
9	81844- Гүнзгий болон төрөлжсөн сургалт	105	105	0.00	79.6

10	81848 - Түрээсийн сурах бичиг	1,048.10	1,048.10	0.00	100
11	83603- бусад хөтөлбөр	2,334.00	2,334.00	0.00	100
<b>Дүн</b>		<b>1,376,073.30</b>	<b>1,373,808.60</b>	<b>2,264.70</b>	<b>99.8</b>
<b>Орон нутгийн төсвөөс</b>					
1	80111-Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	75,925.40	75,925.40	0.00	99.5
2	80112-Нийтлэг үйлчилгээ	83,398.80	81,941.40	1,457.40	100
<b>Дүн</b>		<b>159,324.20</b>	<b>157,866.80</b>	<b>1,457.40</b>	<b>99.7</b>
<b>Нийт дүн</b>		<b>1,535,397.50</b>	<b>1,531,675.40</b>	<b>3,722.10</b>	<b>99.7</b>

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тус байгууллага нь нэмэлт төсвийн дансанд орлого, зарлагын гүйлгээ хийгээгүй байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

